

Гэмт хэргийн гаралтын шалтгаан нөхцөл, хүн амын нягтаршилаас хамаарч дүүргүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байх тул ажлын норм нормативыг тодорхойлж шинжээч, мэргэжилтний орон тоог нэмэгдүүлэх талаар шат дараатай арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

ШИНЖЭЭЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХАД НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БАЙДЛЫН БАТАЛГАА

Ц.МӨНХБАТ

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
8022 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн дэд хурандаа;

А.Гантуул

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Удирдахуйн ухааны профессорын багийн дэд
профессор, цагдаагийн хошууч

Хураангуй: Шинжилгээний байгууллага нь хүний нийгэмд оршиж, хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудын тогтолцооны нэг хэсэг байж, нийгмийн харилцааны нарийн түвэгтэй сүлжээнд холбогдсон төрийн байгууллын нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төр ба иргэний нийгэмтэй амьд холбоотойгоор нийгмийн янз бүрийн нөлөөллийн дунд оршдог.

Нийгэм эдийн засгийн сайн сайхан байдал нь олон талтай үзэгдэл бөгөөд хөнгөлөлттэй орон сууцаар хангуулах, богино хугацаанд тушаал дэвших зэрэг хэлбэрүүдтэй. Үүний зэрэгцээ шинжээчийн амь нас, эрүүл мэнд, гэр бүлд заналхийлэх нь түүний хараат бус байдлыг алдагдуулдаг. Тухайлбал шинжээч өөрийн болон гэр бүлийнхээ гишүүдийн амь нас, хувийн аюулгүй байдлын төлөө айж эмээх, албан тушаал дэвших боломжоо алдах зэрэг нь түүнд хууль бус материаллаг шан харамж авсанаас хавьгүй илүү хор уршгийг авчирна.

Гүйцэтгэж буй хийгээд гүйцэтгэх ёстой үүргийнхээ онцлог, мөн өөрийн нь эд эс болсон шинжээч хараат бус байх зайлшгүй улмаас шинжээч нийгмийн орчны нөлөөнөөс дархлаажсан байхыг шаарддаг тул энэхүү сэдвийн хүрээнд судалгаа хийхийг зорилоо.

Түлхүүр үг: Хараат байдал, хараат бус байдал, шинжээч, мэргэжлийн онцлог, чиг үүрэг, баталгаа.

Оршил

Монгол Улсын эдийн засгийн байдал тийм хүрэлцээтэй чадавхтай биш байна. Шинжилгээний байгууллагын шинжээч орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд хийх зүйл их байгаа бөгөөд хийх ажлуудыг цэгцтэй томъёолон баталгаажуулсан стратеги төлөвлөгөө баримтлах гол бодлого, чиг баримжаа болох ёстой.

Албан ажил мэргэжлийн хараат бус байдал, хувийн хараат бус байдал гэх буюу удирдлага зохион байгуулалтын, улс төрийн, эдийн засгийн хараат бус байдал ч гэж өргөн хүрээнд авч үзэхэд шинэ үзэл баримтлалын учир утга оршино.

Шинжээчийн хараат бус байдлыг хангахад шинжээчдийн эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгаа, хууль эрх зүйн баталгаа, аюулгүй байдлын баталгаа хангагдсан байх ёстой.

Шинжилгээний байгууллагын хараат бус байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ижил зорилготой, адил төрлийн байгууллагатай холбоо тогтоож хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх замаар хөгжингүй орнуудын туршлага, дэмжлэгийг авах ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна.

Техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, орон сууц, тэтгэвэр тэтгэмж зэрэг нийгмийн хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээг хойшлуулалгүй авах шаардлагатай.

Шинжээчийн ажлын нөхцөл, цалин хангамжийг боловсронгуй болгож хүний нөөцийг бэлтгэх, хуваарилах, шалгаруулах, шилж сонгох, зохион байгуулалтын шинэ түвшинд гаргах ёстой. Өөрөөр хэлбэл хамгийн чадварлаг, шударга, ёс зүйтэй, мэдлэгтэй, ажиллана гэсэн үг. Ийнхүү шилж томилогдсон шинжээчид өөрсдийн мэдлэг ур чадвар, шударга байдлаараа өөрийн хараат бус байдлыг дархлаажуулах ёстой.

Шинжээч томилогдон ажиллах байр, тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, ажилтны орон байраар хангах зэрэг хараат бусаар ажиллах нөхцлийг төр бүрдүүлэх ёстой.

Монгол Улсад төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн болон бизнесийн бүлэглэл, хөрөнгө чинээтэй хүмүүсийн нөлөөлөл улам бүр хүчирхэгжиж байгаа талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр өдөр тутам ярьж бичих боллоо.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд ял завших, гэм буруугүй хүн хохирохгүй байх, хүний эрх, эрх чөлөөг хангах гол хүчин зүйл нь шинжээчийн дүгнэлт юм. Хүний эрх, эрх чөлөө хангагдах гол хүчин зүйл бол шинжээч хараат бусаар дүгнэлт гаргах явдал юм. Шинжээчийн хараат бус байдал гэдэг нь

аливаа дарамт. нөлөөллөөс ангид байдлаар зөвхөн баримт нотолгоо, шинжлэх ухааны арга, аргачлал, хуульд тулгуурлан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шинжээчийн дүгнэлт гаргах хэмээн ерөнхий байдлаар тодорхойлж болохоор байна.

Шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хязгаарласнаар байгууллагын хараат бус байдал хангагдана. Байгууллагын хараат бус байдал гэдэгт байгууллагын бүтэц, хуулиар тогтоосон үүрэг, чиглэлийн дагуу бие дааж үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.

Шинжээчийн хараат бус байдлыг дараах байдлаар авч үзвэл зохино.

■ Шинжээчийн хараат бус байдал (гадаад, дотоод хүчин зүйлс)

■ Шүүхийн шинжилгээний байгууллагын хараат бус байдал

Шинжээчийн хараат бус байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйлст хөндлөнгийн аливаа этгээдийн дарамт шахалт, хууль бус санал, хүсэлт, гүтгэх, шинжээчийн гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүнийг шууд болон шууд бус арга хэлбэрээр айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх, хэл амаар доромжлох, үйлчилгээ үзүүлж тал засах, эсхүл үйлчлэхгүй байх, хараах, айлган сүрдүүлэх, найз нөхөд, танил тал, ах, дүү, хамаатан, садангийн хүнээр дамжуулан нөлөөлөхийг оролдох, авлига, хээл хахууль, шан харамж өгөхийг завдах, эдлэх үндсэн эрхийг хязгаарлах зэргээр нөлөөлөх байдал гарч болзошгүй юм.

Шинжээчийн хараат бус байдалд нөлөөлөх дотоод хүчин зүйлст гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагсдаас хууль бус санал, хүсэлт тавих, шан харамж өгөх, шууд удирдах дарга үүрэг болгох гэх мэт нөлөөлөл юм.

Байгууллагын хараат бус байдалд нөлөөлөх хүчин зүйлст яам, агентлаг, улс төрийн намаас нөлөөлж хууль бус шийдвэр гаргуулах, төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, иргэд, нийгмийн цахим сүлжээ (facebook, youtube, twiter) дарамт шахалт үзүүлэх, сүрдүүлэх, гүтгэх, заналхийлэх, худал мэдээлэл тараах зэрэг нөлөөлөл юм. Энэ асуудлыг судлан тогтоож, нийгмийн энэхүү сөрөг, эрүүл бус үзэгдлийн эсрэг хараат бус байдлыг хамгаалах нь зайлшгүй хийх ажил болоод байна.

Шинжээчийн хараат бус байдлаар ажиллахад эдийн засгийн баталгаа, нийгмийн баталгаа, хууль эрх зүйн баталгаа, аюулгүй байдлын баталгаа хангагдсан байх ёстой.

Эдийн засгийн баталгаа: Шинжээчийн эдийн засгийн хараат бус байдлыг хангах анхдагч бөгөөд чухал арга бол шинжээчийн цалин, хангамж, ажлын байрны гадны нөлөөнд автах аргагүй байдал гэж үздэг. Шинжээчийн албан тушаалын цалин төрийн албан хаагчийн цалингийн сүлжээний дунд түвшинд байж, дээр нь цолны нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, онцгой

албаны зэрэг нэмэгдэл нэмэгдэж шинжээчийн цалин тэдний хараат бус байдлын баталгаа болж чадахгүй байгааг нуух аргагүй. Эцсийн дүндээ шинжээчийн хараат бус байдал нь баталгаатай цалин хөлс, тогтвортой ажлын байр гэсэн хоёр ойлголтын нэгдлээр хангагдана.

Шүүгчийн “хараат бус байдлыг” хангахад шүүгчийн цалинг зайлшгүй нэмэх шаардлагатай гэж Монгол Улсын Их Хурал. Шүүхийн ерөнхий зөвлөл, бүх шатны шүүхийн шүүгч, эрдэмтэн, судлаачид үзсэн байна. Шүүхийн төсөв, шүүгчийн цалин бага байгаа нь шударга ёсыг үнэгүйдүүлэх, шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг алдагдуулах, цалингийн зээлтэй шүүгчдийг банк, мөнгөний барьцаанд оруулах аюултай. Иймээс төсөв санхүүгийн хүндрэл бэрхшээл байсан ч шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг илүү баталгаажуулах шаардлагатай гэж үзэн Монгол Улсын Их Хурлаас 2013 онд өмнөхөөс өндөр болгож тогтоосон нь шүүгчийн хараат бус байдлыг хангах чухал алхам болсон юм. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 101 дугаар тогтоолоор шүүгчийн цалинг дахин шинэчлэн 2,7-3,2 сая төгрөгөөр тогтоожээ.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйл. Шүүгчийн эдийн засгийн баталгаа. 23.1 дэх хэсэгт “Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна.”¹ гэж заажээ.

Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөгч нар шинжээчийн дүгнэлтийг үндэслэн аливаа хэрэг, зөрчил, маргааныг шийдвэрлэдэг. Гэмт хэргийг илрүүлэхэд үнэн бодит нотлох баримт чухал байдаг. Эх нь булингартай бол адаг нь булингартай гэдэг монгол ардын зүйр үг бий. Уг нь нотлох баримт бүрдүүлж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөгч, шинжээч нарын цалин, орон байр, хангамж, урамшуулал, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулснаар хараат бусаар ажиллах нөхцөл бүрдэж, хүний эрх, эрх чөлөө хангагдах ёстой болов уу.

Шинжээчийн хараат бус байдлыг хангахад нөлөөлж буй асуудлын талаар хийсэн судалгаанд хамрагдсан Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 51 шинжээчээс Та зээлтэй юу? гэсэн асуулгад цалингийн зээлтэй гэж 54 хувь нь, орон сууцны зээлтэй гэж 28 хувь нь, бусад зээлтэй гэж 18 хувь нь хариулсан бөгөөд судалгаанд хамрагдсан бүх шинжээч бүгд зээлтэй гэж хариулжээ. Цалин нь гэр бүлийн хэрэгцээний хэдэн хувийг эзлэж байна вэ? гэсэн асуулгад 10 хувийг хангадаг гэж 12 хувь нь, 30 хувь хангадаг гэж 43 хувь нь, 50 хувь хангадаг гэж 35 хувь нь, 70 хувь хангадаг гэж 10 хувь нь хариулсан байна. Шинжээчийн сарын цалин нь гэр бүлийн өдөр тутмын хэрэгцээнд зарцуулагдахаас, сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх гэх мэт бусад хэрэгцээг хангаж чадахгүй байна. Шинжээчдийн цалин ийм бага, судалгаанд хамрагдсан

¹ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, УБ., 2012 он.

шинжээчид бүгд зээлтэй байгаа нь тэднийг хараат бусаар ажиллахад нөлөөлж болзошгүй гол хүчин зүйл тул Сум дундын прокурорын газрын хяналтын прокурор сарын цалинтай ойртуулах шаардлагатай байна. Шинжээчдийн хараат бус байдлыг баталгаажуулах нэг суурь нөхцөл бол шинжээчийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах явдал юм.

Нийгмийн баталгаа: Шинжээчийн нийгмийн баталгаа нь цаг үетэйгээ нийлсэн, тэдний нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх учиртай юм. Төрийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн шинжээчдийг ажиллах нөхцөл боломж, нийгмийн баталгааг хангах, давуу эрх, хөнгөлөлт, тэтгэмж зэрэг нийгэм ахуйн баталгаагаар хангах үйл ажиллагааг зохицуулах зүй ёсны шаардлага байна. Хамгийн наад зах нь тогтвортой ажиллах, өөрийгөө хөгжүүлэх орчин болгох, ажлаа сэтгэл хоёрдохгүй хийх нөхцөл, боломжийг бүрдүүлэх ёстой юм.

Хувийн хараат бус байх нь нэн төвөгтэй асуудлын нэг мөн. Энэ нь шинжээчийн дэвших, буурах, аж амьралын нөхцөл, юуны өмнө цалин, нийгмийн хангамж, хангамжийн тогтолцоо, хэр хэмжээ, тэр ч байтугай шагнаж урамшуулах, нь зохистой эсэх хүртэл хөндөж яригддаг олон эмзэг асуудлыг багтаадаг. Тэр бүхэнд тохирсон оновчтой төлөвлөлт шаарддаг.

Шинжээчийн цалин хөлс, орон байр, хангамж, урамшуулал, ажиллах орчин, нөхцөл муу байгаагаас авлигад өртөх, хээл хахууль, шан харамж авахгүй гэх баталгаа байхгүй байна. Нотлох баримт бүрдүүлж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөгч, шинжээч нарын цалин, орон байр, хангамж, урамшуулал, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулснаар хараат бусаар ажиллах нөхцөл бүрдэж, хүний эрх, эрх чөлөө хангагдана.

Монгол Улсын шүүгч хараат бус байдлаар ажиллахад нийгмийн баталгааг шинжээчийн нийгмийн баталгаатай харьцуулан үзэх зүй ёсны боловуу.

Монгол Улсын шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйл¹. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн хамгаалалт.

24.1. шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцна.

24.2. шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал дараах хэлбэр, хэмжээтэй байна:

24.2.1. шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодь нь бэртсэн буюу эрүүл мэндэд нь гэмтэл учирснаас нас барсан бол даатгалын төлбөрийг түүний авч байсан сүүлийн 15 жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр шүүгчийн өв залгамжлагчид төлөх;

¹ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, УБ.. 2012 он.

24.2.2. шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодь нь бэртсэн буюу эрүүл мэндэд нь цаашид мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж чадахааргүй гэмтэл учирсан бол даатгалын төлбөрийн хэмжээ нь тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалинтай тэнцэх;

24.2.3. шүүгчийн бие махбодь, эрүүл мэндэд хохирол учруулсан нь түүний хөдөлмөрийн чадварыг цаашид мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэхэд саад болохоор алдагдуулаагүй бол даатгалын төлбөрийн хэмжээ нь тухайн шүүгчийн сүүлийн нэг жилийн цалинтай тэнцэх.

24.3.энэ хуулийн 24.2-т заасан даатгалын төлбөрийг улсын төсвөөс гаргаж даатгалын байгууллагаас төлнө.

24.4.шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад бэртсэн болон эрүүл мэндэд нь өөр гэмтэл учирснаас цаашид мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүйгээр хөдөлмөрийн чадвараа алдсан бол түүнд шүүгчээр ажиллаж байхдаа авч байсан цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг сар бүр олгоно.

24.5.шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад нас барвал түүний асрамжид байсан хүүхдийг 18 нас хүртэл нь, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд шүүгчийн авч байсан албан тушаалын цалингаас ногдох хэмжээгээр тэтгэмж /нөхөх төлбөр/ийг сар бүр олгох бөгөөд түүнд улсын төсвөөс төлсөн даатгалын төлбөр, тэжээгчээ алдсаны болон бусад төрлийн тэтгэвэр, цалин, тэтгэлгийг оруулан тооцохгүй гэж заажээ.

Орон нутагт төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлж байгаа шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага нь албаны орон сууцтай бөгөөд томилогдон ажиллаж байгаа албан хаагчид ямар нэг санаа зовох зүйлгүйгээр “хараат бус байдал”-аар ажиллаж, амьдарч байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Аймгийн шүүхийн шинжилгээний албанд томилогдон ажиллаж байгаа албаны дарга, шинжээч нар түрээсийн байранд сарын 150-300 мянган төгрөгийн түрээс төлж амьдарч байна.

Шинжилгээний байгууллагын ажилтан нь байр түрээслэж, хэрэгцээнд хүрэлцэхгүй цалингаар амьдарч байгаа нь “хараат бус байдал”-аар ажиллах нөхцөл бүрэлдэхгүй байна. Харин байр түрээслүүлэгч эзэн, хөрөнгө мөнгөтэй хүний эрхшээлд хараат байдалд өөрийн эрхгүй орох нөхцөл нэгэнт бүрдсэн байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын дүүргийн шинжилгээний тасаг, Аймгийн шүүхийн шинжитлгээний алба нь цагдаагийн байгууллагын байранд байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байгаа нь төсөв санхүү, удирдлагын зүгээс хараат бус байгаа боловч үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын “хараат байдал” байна.

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйл. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа:

43.1. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана.

43.2. Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно.

43.3. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.

43.4. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно.

43.5. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно гэж заасан.

Энэ хуулийн зүйл заалт нь шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтаны нийгмийн асуудлыг бүрэн шийдэж чадах боломжгүй болсон байна.

Монгол Улсад эрх зүйн шинэтгэл 2017 оноос эрчимжиж, төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагууд хуулиа шинэчлэн албан хаагчдынхаа улс төрийн баталгаа, нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгаа, хууль эрх зүйн баталгаа, аюулгүй байдлын баталгааг хуульчилж өгсөн байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийг шинэчлэн найруулж, улс төрийн баталгаа, нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгаа, хууль эрх зүйн баталгаа, аюулгүй байдлын баталгааг хуульчлах цаг нэгэнт бий болжээ.

Ингэхдээ Шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээч нарын хууль, эрх зүй, нийгмийн асуудлыг цогц байдлаар шийдэх нь олон олон шийдвэрлэгдээгүй асуудлыг шийдэх болно.

Хууль, эрх зүйн баталгаа: Шүүхийн шинжилгээний байгууллага нь шинжилгээ томилж буй этгээд, болон улс төрийн нам, яам, агентлаг, төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, ашиг сонирхолын зөрчилтэй этгээдээс үйл ажиллагаа, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах нь чухал байсан тул Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулж, Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо.

Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг баталсан.

Монгол Улсын Их хурлын 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Шүүхийн шинжилгээний тухай” хууль батлагдсан нь үйл ажиллагааны зарчим, чиг үүргийг тодорхойлж, байгууллагын тогтолцоог баталгаажуулсан анхны бие даасан хуультай болсон.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь шинжилгээ томилж буй этгээд, болон улс төрийн нам, яам, агентлаг, төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, ашиг сонирхолын зөрчилтэй этгээдээс үйл ажиллагаа, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах нь чухал байсан тул Монгол Улсын Их хурлын 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Шүүхийн шинжилгээний тухай” хууль батлагдсан нь үйл ажиллагааны зарчим, чиг үүргийг тодорхойлж, байгууллагын тогтолцоог баталгаажуулсан анхны бие даасан хуультай болсон.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 42 дугаар зүйлд ...”хуулийг дээдлэн биелүүлж, гагцхүү шинжлэх ухааны бодит үнэнд захирагдан үнэнчээр ажиллаж, төрийн тусгай албан хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахихаа батлан тангараглая” гэсэн нь шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан тангарагтаа үнэнч байж, сахин биелүүлэх нь үүрэг юм.

Шинжилгээ хийлгэх тухай тогтоолд тавьсан асуулт шинжээчийн тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, эсхүл тавьсан асуултад шинжлэх ухааны арга, хэрэгсэл ашиглан хариулах боломжгүй бол шинжээч шинжилгээ хийх, дүгнэлт гаргахаас татгалзана¹ гэж заасан. Дээрх хуулийн заалтууд нь шинжээч хараат бусаар ажиллах эрх зүй орчин бүрдсэн байна. Гэвч шинжээчийн хараат бус байдалд халдсан заалт Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан байна.

Тухайлбал, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлийн шинжээчийн эрх, үүрэг дэх хэсгийн 3-т дүгнэлт гаргасан шинжээч нь мэдүүлэг авахаар шүүх, прокуророос дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг энэ хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ^{1 2} гэж заасан нь шинжээчийн эрх, үүрэг, зүй бусаар халдсан, хараат бус дүгнэлт гаргах боломжийг хязгаарласан заалт юм.

Шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийн эрх зүйн зохицуулалт Шүүхийн шинжилгээний тухай хуулиас өөр хууль, эрх зүй зохицуулалт байхгүй байна. Иймд шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийж буй шинжээч нарын нийгэм, эдийн засаг, хуул, эрх

¹ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Улаанбаатар хот, 2017 он

² Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Улаанбаатар хот, 2017 он

зүй, аюулгүй байдлын баталгааг хангах, төрийн бус байгууллагын шүүхийн шинжилгээний тухай хууль, эрх зүйг бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Аюулгүй байдлын баталгаа: Эрдэмтэн судлаачид "Аюулгүй байдал" гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарласан байдаг. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг. Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг "Британика" нэвтэрхий тольд "Аюулгүй байдал-амар тайван, бат бэх, итгэлтэй байх нөхцөл байдал, аюул болон эрсдэлээс чөлөөтэй байх"¹ гэсэн бол Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд "аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй"^{1 2} гэж тайлбарлажээ.

Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т "Хүний аюулгүй байдал" гэдэгт "Монгол хүний эрүүл. аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн"³ гэж заасан байна.

Хүн өөрийнхөө аюулгүй байдлыг хангахад оюун ухаан, практик, материаллаг зүйлийг ашиглах бололцоо дэлхийн амьд амьтны үй олон төрөл зүйл дотроос зөвхөн хүнд байдаг онцгой шинж юм.⁴ Иймээс хүн төрөлхтөн өөрийн эсрэг заналхийлж буй хүчин зүйлийг танин мэдэж, урьдчилан сэргийлэх буюу арилгах арга замыг хайж сүвэгчилж байдаг билээ.

Хүний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг: эх сурвалжаар нь дотоод, гадаад, цаг хугацааны хувьд гэнэтийн, тодорхой хугацааны, түүхэн нэгэн үеийн, мөнхийн, хэмжээ далайцаар нь дэлхий дахины, тив, бүс нутаг гэх мэтчлэн ангилж болно.

Нөгөө талаар хүний аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх хүчин зүйлийг шинж чанарын үүднээс нь обьектив болон, субъектив. учруулах аюул заналын магадлалаар нь бодит болон болзошгүй хэмээн үздэг. Хүний аюулгүй байдлыг ханган бэхжүүлэхэд "болзошгүй" үед тодруулан тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар бодит аюулыг багасгах, урьдчилан сэргийлж байдаг ажээ. Хүний аюулгүй байдал нь өөр хоорондоо эдийн засгийн.

¹ <https://mn.wikipedia.org/wiki>

² Цэвэл.Я, Монгол хэлний товч тайлбар толь, УБ, 1966 он.

³ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол.

⁴ Мухамеди.Х, Хүний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйл, УБ.. 2000 он.

хүнсний. эрүүл ахуйн, байгаль орчны, мэдээллийн, улс төрийн гэх мэт өргөн хүрээтэй олон асуудал, хүчин зүйлсийг хамардаг.

Шинжээч нь бусад хүний адил орох орон байр, өмсөх хувцас, ажил хөдөлмөр эрхлэх, гэмт хэрэгтний гарт өртөлгүй эсэн мэнд байж. үр хүүхдээ өсгөн бойжуулж, насаа элээхийг хүсдэг нь зайлшгүй юм. Шинжээч нь улс төр, эдийн засаг, хүний амь нас хохирсон, мансууруулах бодис гэх мэт хэргүүдэд шинжилгээ хийдэг. Шинжээч ямар төрлийн шинжилгээ хийснээрээ аюулгүй байдал нь хөндөгдөж болох юм.

Ингээд төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын аюулгүй байдлыг хэрхэн хамгаалсан талаар авч үзье.

Төрийн албан хаагч нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.4 дэх хэсэгт заасан “Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулах”¹ нийтлэг баталгаагаар хангагдана.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйл. Шүүгчийн халдашгүй байдлын 26.4 дэх хэсэгт “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, аюулгүй байдалд аюул занал учрах нөхцөл үүссэн болон энэ тухай мэдээлэл авсан бол цагдаагийн байгууллага энэ байдлыг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй”, 26.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.4-т заасан арга хэмжээг авах нөхцөл, журмыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, цагдаагийн төв байгууллагын дарга хамтран батална.” 26.6 дэх хэсэгт “Шүүгч нь аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор бие хамгаалах хэрэгслийг эзэмших, биедээ авч явах эрхтэй.” гэж заажээ.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт “Иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан “Цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно”.

39.3 дахь хэсэгт “Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцна”.¹²

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 85.6 дахь хэсэгт “Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч болон түүний

¹ Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. УБ., 2017 он.

² Монгол Улсын Хилийн тухай хууль, УБ.. 2016 он.

хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг цагдаагийн байгууллага хариуцна”.¹

Монгол Улсын Тагнуулын байгууллагын тухай хуулийн 24.11 дэх хэсэгт “Албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан тагнуулын ажилтан, гүүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн тохиолдолд тагнуулын байгууллага аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна”.²

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 30.3 дахь хэсэгт “Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан буюу албан үүрэгтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон бол түүний ар гэрт 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно”.

32.3 дахь хэсэгт “Албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан Авлигатай тэмцэх газрын албан хаагч болон гэр бүлийнх нь гишүүдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна”.³

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 283.4 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг гэмт хэрэг, зөрчил болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний аюулгүй байдлыг хангах зорилгоор албан тушаал бууруулахгүйгээр өөр байгууллага, нэгжид сэлгэн ажиллуулж болно.”

285.4 дэх хэсэгт “Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцна.”

286.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.”

286.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан

¹ Монгол Улсын цагдаагийн албаны тухай хууль, УБ., 2017 он.

² Монгол Улсын Тагнуулын байгууллагын тухай хууль, УБ., 1999 он.

³ Монгол Улсын Авлигын эсрэг хууль, УБ., 2006 он.

эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол энэ хуулийн 286.1-д заасан баталгаа нэгэн адил хамаарна.”

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 49.3 дахь хэсэгт “Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүнийг гэр бүлд нэг удаа олгоно.”^{1 2}

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43.1 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана³ гэж заажээ.

Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээчид эрүү, иргэн, захиргааны хэрэг, зөрчлийн Монгол Улсад хийгдэж буй шинжилгээний дийлэнх хэсгийг хийдэг.

Энэ тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй шинжээчийн аюулгүй байдал Төрийн албаны тухай хуулийн 61.1.4 дэх хэсэгт заасан баталгаанаас өөр аюулгүй байдлын баталгаа байхгүй байна. Шинжээчийн амь биед хэн нэгэн этгээд халдсан тохиолдолд хамгаалах хэрэгсэл хэрэглэж болох тухай хуулийн зүйл, заалт ч алга.

Мөн төрийн байгууллагад ажилладаггүй шинжээчийн аюулгүй байдлын баталгаа хангагдаагүй байна.

Иймд шинжээчийн аюулгүй байдлыг хангах гол баталгаа бол хууль, эрх зүйн баталгаа, нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх явдал юм.

ДҮГНЭЛТ: Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдаж нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд шинэ ойлголтууд бий болж эрх зүйн салбарт шинэтгэл хийх үйл явц эрчимтэй өрнөж эхэлсэн билээ. Үүнтэй уялдаж эрүү, иргэн, захиргааны болон бусад салбар эрх зүйн зохицуулалтын нийгмийн харилцаа өргөжихийн хирээр хэргийн гэм бурууг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлон тогтоох үйл ажиллагаанд ч тодорхой ахиц өөрчлөлт гарч эхэлсэн.

Сүүлийн жилүүдэд шинжилгээний байгууллагад үл итгэх байдал иргэдийн дунд бий болж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хэт нэг талыг барьсан нэвтрүүлэг гарах, нийгмийн цахим сүлжээгээр гүтгэлгийн шинжтэй мэдээлэл түгэх болсон нь анхаарал татаж байна. Нийгмийн энэхүү сөрөг үзэгдэл нь нөгөө талдаа шинжилгээний байгууллагыг үйл ажиллагаагаа бие даасан. хараат бус байдлаар явуулах, шинжээч хараат бус байдлаар ажиллахыг өнөөгийн нийгэм шаардаж байгаагийн нэг илрэл гэж ойлгож болно.

¹ Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УБ., 2016 он.

² Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2017 он.

³ Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль. УБ., 2009 он.

Шинжилгээний байгууллага. шинжээчийн үйл ажиллагаа хууль ёсны дагуу. шударга, бусдын аливаа нөлөөнд автахгүй, "хараат бус байдал"-аар ажиллах шаардлага чухлаар тавигдаж буй өнөө үед шинжээчийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах асуудал туйлын чухал бөгөөд цалин хөлс. орон байр, хангамж, урамшуулал, ажиллах орчин, нөхцөл муу байгаагаас авлигад өртөх, хээл хахууль авахгүй гэх баталгаа байхгүй байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хийгддэггүй барилга инженер, байгаль орчин, эд хөрөнгийн үнэлгээний гэх мэт шинжилгээнүүд "хараат бус байдал"-аар шинжээчийн дүгнэлт гардаг гэдэг нь эргэлзээтэй байна. Иймд шүүхийн шинжилгээний байгууллагад ажилдаггүй шинжээч нарыг шүүхийн шинжилгээ хийх эрх олгодог болох, аттестатчилах мөн төрийн бус шүүх шинжилгээний хууль, эрх зүйг бий болгох нь өнөөгийн нийгмийн захиалга гэж үзэж байна.

САНАЛ: Монгол Улсад сүүлийн жилүүдэд тодорхой мэргэжлийн тухайлбал шүүгчийн хараат бус байдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол ярьж, бичиж байна. Харин шүүгч шинжээчийн дүгнэлтийг нотлох баримт гэж үнэлэн гэмт хэрэг, зөрчил, маргааныг шийдвэрлэдэг. Иймд шинжээчийн дүгнэлт гэмт хэрэг, зөрчил, маргааныг шийдвэрлэхэд голлох нотлох баримт болдог тул "шинжээчийн хараат бус байдал"-ыг өнөөдөр зайлшгүй авч үзэж, шийдвэрлэх шаардлагатай юм. Иймд судалгааны ажлын дүгнэлтийг үндэслэн дараах саналуудын дэвшүүлж байна.

Монгол Улсад эмчлэх эрхийн, багшлах эрхийн, хуульч, өмгөөлөгч, өмгөөллийн, нотартийн гэх мэт тодорхой төрлийн ажил мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг шалгалт өгч, тавигдах шалгуур шаардлагуудыг хангасан этгээдэд олгодог. Үүнтэй нэгэн адил шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийгддэг шинжилгээний талаар илүү өргөн хүрээний зүйл, заалтыг оруулж, шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь шаардлагатай байна.

Шинжээч, мөрдөгч зэрэг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нотлох зэрэг чиг үүрэгтэй ажилладаг мэргэжлийн алба хаагчдын цалинг зарим албан туушаалтны цалинтай харьцуулан үзвэл шүүгчийн цалингаас 4 дахин, прокурорын цалингаас 2,7 дахин тус тус бага байгаа нь тэдний хараат бусаар ажиллахад нөлөөлөх хүчин зүйл болох магадлалтай юм. Иймд шинжээчийн сарын цалинг сум дундын прокурорын газрын хяналтын прокурорын сарын цалингийн жишигтэй ойртуулах, жишиг цалингийн сүлжээ шатлалыг бий болгох, судлах шаардлагатай гэж үзэж байна.

Аймаг, орон нутгийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагууд нь албаны мэдлийн орон сууцтай, гэр бүлийн хүнийг нь ажлын байраар хангах үүргийг хуулиар зохицуулж өгсөн байна. Аймгийн шүүхийн шинжилгээний алба нь албаны мэдлийн орон сууцгүй тул шинжээч, албаны дарга нар түрээсийн орон сууцанд сарын 150-300 мянган төгрөгийн түрээс төлж, гэр бүлийн хүн нь ажилгүй, ганц хүний цалингаар амьдарч байгаа тохиолдол цөөнгүй байна. Иймд аймгийн шүүхийн шинжилгээний алба нь албаны мэдлийн орон сууцтай болох шаардлагатай байна.

Аймгийн шүүхийн шинжилгээний алба, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын харьяа дүүргийн Криминалистикийн шинжилгээний тасгууд цагдаагийн байранд байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байгааг хараат бус байдал алдагдаж байна гэж үзэж болно.

Аймаг, орон нутагт хийх боломжгүй зарим нарийн шинжилгээний дээж, материалыг шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд тээвэрлэн хүргүүлж шинжлүүлэхэд цаг хугацаа алдах, санаатай болон санамсаргүйгээр тээвэрлэлтийн явцад шинжилгээний объект устах, солигдох, чанараа алдах, шинжилгээ болон шинжээчийн дүгнэлтийн нууцлал алдагдах, иргэдийг чирэгдүүлэх явдал байсаар байна. Иймд аймаг, орон нутагт бүсчилсэн хэлбэрээр бүсийн төв лабораториудыг байгуулах, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори, Гаалийн лабораторийн уялдаа холбоог сайжруулж, аймаг, орон нутагт зарим төрлийн шинжилгээ хийдэг болох шаардлагатай.

Шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдэж буй шинжилгээ бүрийг кодлох нь шинжээч бусдын ямар нэгэн нөлөөнд үл автаж, шинжээч "хараат бус байдлаар" шинжилгээ хийх нөхцөл нь бүрдэнэ. Ингэснээр шинжээчийн эрх зүйн баталгаа, аюулгүй байдлын баталгаа хангагдана. Иймээс шинжилгээний үйл ажиллагаанд кодлох аргыг нэвтрүүлэх нь зүйтэй.

Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй шинжээч нь ямарч үед гэмт хэргийн газар хүрэлцэн очиж, үзлэг, шинжилгээ хийдэг. Иймд Шүүхийн шинжилгээний тухай хуулинд шинжээчийн амь биед халдсан тохиолдолд хамгаалах хэрэгсэл хэрэглэх тухай хуулийн зүйл, заалтыг бий болгох шаардлага байна. Мөн шинжээчийн нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх явдал чухал байна.

Шинжилгээний байгууллагын хараат бус байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ижил зорилготой. адил төрлийн байгууллагатай холбоо тогтоож хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх замаар хөгжингүй орнуудын туршлага. дэмжлэгийг авах ажлыг зохион байгуулах хэрэгтэй гэсэн саналуудыг дэвшүүлээ.